



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1977 оны 6 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар
хот

Улаанбаатар хотын гүйцэтгэх захир-
гаанд Хөдөө аж ахуйг удирдах газар
байгуулах тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны хөдөө аж ахуйн хэлтсийг өргөтгөх замаар Хөдөө аж ахуйг удирдах газрыг энэ оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн байгуулж Улаанбаатар хотын хөдөлмөрчдийг төмс, хүнсний ногоо, сүүгээр хангах үүргийг хариуцуулсугай.

2. Улаанбаатар хотын Хөдөө аж ахуйг удирдах газар байгуулсантай холбогдуулан, Хөдөө аж ахуйн яамны харъяа Сүү, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэгдлийг 1977 оны 7 дугаар сарын 1-нээр татан буулгасугай.

3. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны Хөдөө аж ахуйг удирдах газрын орон тоог хавсралтын ёсоор баталсугай.

4. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд Гачуурт, Партизан сангийн аж ахуй, Шувуу фабрик, Гахай бордох завод, Ногооны комбинат, Мал эмнэлгийн газрыг харъяалуулсугай.



БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
нэгдүгээр орлогч дарга

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн
Хэрэг эрхлэх газрын дарга

Д.МАЙДАР

Б.БАДАРЧ



Сайд нарын Зөвлөлийн 1977 оны
183 дугаар тогтоолын хэсгээр

**УЛААНБААТАР ХОТЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ХӨДӨӨ АЖ АХУЙГ УДИРДАХ ГАЗРЫН ОРОН ТОО**

Ажсан тусламь	! нэгж
1. Газрын дарга	1
2. Орлогч дарга бөгөөд зоотехникч	1
3. Ахлах агрономч	1
4. Ахлах инженер	1
5. Мэргэжилтэн	5
6. Бичиг хэргийн эрхлэгч-бичээч	1
ДҮН	10